*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2020 оны 100 дугаар тушаалын*
*7 дугаар хавсралт*

## СУДАЛГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | # | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлого, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020-2024), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны стратеги төлөвлөгөө /2020-2024/, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛТ 1. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛНА. | | | | | | | | |
| 1.1. | | “Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2024 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлын зохион байгуулах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | | | |
| 1.1.1 | 1 | Салбарын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тайлан, мэдээг нэгтгэн боловсруулах, хуулийн | - | Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн байх | 0 | 1 | “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг Салбарын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тайлан, мэдээг тухай бүр нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлсэн. Үүнд:<br>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023 оны үйл ажиллагааны үр дүн, онцлох ажлуудын талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т 2024.01.02-ны өдөр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | | | | | | -“Монгол Улсын Засгийн газрын 2021-2023 онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд” товхимолд салбарын талаар тусгах мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т /2024.01.16/ хүргүүлсэн.<br>-Гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан хийлгэх судалгаа, мэдээллийн саналыг холбогдох газарт хүргүүлсэн.<br>-“Бүсчилсэн хөгжлийн урьдчилсан хэлэлцүүлгийн хүрээнд Говийн бүс /Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр/-ийн хөгжлийн асуудлаар санал солилцсон.<br>-“Монголын эдийн засгийн чуулган”-ы хуралдаанд оролцож, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөлд санал өгсөн.<br>-Монгол Улсын Ерөнхий сайдын УИХ-ын 2024 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд хийх мэдээллийн бэлтгэсэн.<br>-Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд болон стратегийн ордод хамааруулах боломжтой ордуудын талаар мэдээлэл бэлтгэсэн.<br>-“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төсөлд санал өгч, 2024.04.12-ны өдрийн 01/830 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>-Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд болон стратегийн ордод хамааруулах боломжтой ордуудын талаар танилцуулга бэлтгэсэн.<br>-Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцын мэдээллийг нэгтгэж хүргүүлсэн.<br>-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын оролцоог хангах, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Засгийн газартай байгуулах Санамж бичгийн төслийг боловсруулж, 2024 оны 3/953 дугаар албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлж, гарын үсэг зурсан.<br>-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сар, улирлаар нэгтгэн боловсруулж тайлагнасан.<br>-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг гарган 2024.09.06-ны өдөр хүргүүлсэн.<br>-Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг 2024 оны 01/502 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>-Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг урт, дунд хугацааны бодлогод нийлүүлэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулж 2024.08.26-ны өдрийн 01/101 дүгээр албан бичгээр Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлсэн | |
| 1.1.2 | 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | - | Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн байх | 0 | 1 | Салбарын холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2023 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэх, тайлагнах ажлыг зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл, хууль тогтоомжийн хэрэгжилт, газар, хэлтсийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг боловсруулж, тухай бүр тайлагнаж ажилласан. Тухайлбал, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан төслийн хэрэгжилтийг нэгтгэж, холбогдох газарт тайлагнасан. УИХ, Засгийн газраас баталсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар, улирлаар нэгтгэн боловсруулж, тухай бүр холбогдох газарт /ТЗУГ/-т хүргүүлж ажилласан. Тухайлбал: ““Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2015 оны 332 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2024.05.03-ны өдрийн 02/1021 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн “Хуримтлалын сан улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай” Засгийн газрын тогтооолын төсөлд санал өгч, 2024.05.29-ний өдрийн 01/1194 дүгээр албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 1.1.3 | 3 | Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | - | Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн байх | 0 | 1 | Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын 2020 оны 11 дүгээр сарын 18, 19-ний өдрийн Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээрийн протоколын дагуу Сангийн яамнаас ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хариу албан бичгээр “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ ТД 2020.2036.0” төслийг хэрэгжүүлэх тохиролцоог баталгаажуулж, 2022 оны 4 дүгээр сараас эхлэн тус яаманд хэрэгжиж байна. ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны шийдвэрийн дагуу хоёр тал харилцан тохиролцож, төсөл хэрэгжүүлэх гэрээний дуусах хугацаа 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байсныг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаж, санхүүжилтийг 550,000 сая еврогоор нэмэгдүүлж 2,550,000 евро болгосон. Төсөл хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт өөрчлөгдсөнтэй холбогдуулан төслийн үйл ажиллагааны төлөвлөөг шинэчилж баталсан. Төлөвлөгөөний дагуу биелэлтийг хангаж ажилласан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 2019 оны 6 дугаар сараас эхлэн "Олборлох салбарын засаглалыг сайжруулах" (TA 9752 MON) төсөл хэрэгжиж байна. Төслийн хугацаа 2021 онд дуусахтай холбоотойгоор Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах олон талт итгэлцлийн сангаас 500.0 мянам.долларыг 2022-2023 онд олгохоор болж 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдөр TF0B8169 тоот тусламжийн гэрээнд талууд гарын үсэг зурсан. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх" төслийн 2022-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Австрали-Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /AMEP/-ийн холбогдох албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулж, олборлох үйлдвэрлэлийн салбар дахь Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)-ын хамрах хүрээ, стандарт, хэм хэмжээ, АМНАТ-ийн зэрэг судалгааны ажлуудыг гүйцэтгүүлэхээр санал солилцсон. Уулзалтын үр дүнд Австрали Улсын Засгийн газрын санхүүжилтээр манай орны олборлох үйлдвэрлэлийн салбар дахь Байгаль орчин, нийгмийн засаглал (ESG)-ын түргэвчилсэн үнэлгээний тайланг боловсруулж, салбарын аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад сургалт зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан. | |
| **Зорилт 2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулна.** | | | | | | | |
| 2.1 | 1 | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | - | Хуулийн төсөл Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад хуульд нийцсэн байх | Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байх | Хуулийн үзэл баримтлал батлагдсан байх | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал, хуулийн төслийн эцсийн найруулга болон танилцуулгын төслийг бэлтгэж, хэвлэн нийтлүүлсэн. Хуулийн төслийг PDAC-2024, Боомтын сэргэлт, Бүсчилсэн хөгжлийн хэлэлцүүлгийн зэрэг гадаад, дотоодын чуулга уулзалт, нэгдсэн арга хэмжээний үеэр олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулсан. | 90 |
| 2.2 | 2 | Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ. | - | Эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн байх | 0 | 1 | Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийг шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон бусад хуулиудтай нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөрчлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хууль хоорондын уялдааг сайжруулах зарчимд нийцүүлсэн. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар эдийн засаг, үйл ажиллагааны уялдааг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах болон хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, урамшуулал үзүүлэхэд чиглэсэн зохицуулалтууд тусгагдсан. Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар шинэчлэн байгуулсан Ажлын хэсгийн хуралд /2024.01.15/ оролцож санал өгсөн.<br>Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, олон улсын уул уурхайн салбарт мөрдөж байгаа хуулиудыг өөрийн орны эрх зүйн орчин, бүс нутгийн онцлогтой харьцуулсан судалгаа, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжүүлгэд ногдуулах албан татварын хувь хэмжээг оновчтой тодорхойлоход чиглэсэн тооцоо, судалгааг хийсэн. Ашигт малтмал, газрын тосны газраас “Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны судалгаа” боловсруулж ирүүлсэн. Уг судалгаа нь Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг шинэчлэхэд чухал ач холбогдолтой судалгаа болсон. | |
| 2.3 | 3 | Салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан төсөлд санал зөвлөмж өгөх, хуульд нийцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх | - | Боловсруулж, хүргүүлсэн байх | 0 | 1 | УИХ, Засгийн газраас баталсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр холбогдох газарт тайлагнаж ажилласан. Үүнд:<br>- “Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2015 оны 332 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2024.05.03-ны өдрийн 02/1021 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>- “Хуримтлалын сан улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2024.05.29-ний өдрийн 01/1194 дүгээр албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Ерөнхий сайдын УИХ-ын 2024 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд хийх мэдээллийг нэгтгэн боловсруулсан.<br>- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд болон стратегийн ордод хамааруулах боломжтой ордуудын талаар мэдээлэл бэлтгэсэн.<br>- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд санал өгч, 2024.04.12-ны өдрийн 01/830 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>- “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын протоколд иргэний нийгмийн оролцоог дэмжих тогтоол гаргуулах тухай” саналыг 2024.04.12-ны өдрийн 03/829 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцын мэдээллийг нэгтгэж хүргүүлсэн.<br>- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сар, улирлаар нэгтгэн боловсруулж тайлагнасан.<br>- "Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2024.04.29-ний 02/947 дугаар албан бичгээр СЯ-нд хүргүүлсэн.<br>- 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийн дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын нөөц сангаас "Хөрөнгө гаргах тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2024.01.18-ны өдрийн 01/141 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг боловсруулж, 2024 оны 01/502 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн | |
| **Зорилт 3. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, шаардлага хэрэгцээг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2023 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна.** | | | | | | | | |
| **3.1. Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, статистикийн мэдээлэл, судалгаа шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | | |
| 3.1.1 | 1 | Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулна. | - | Төлөвлөсөн хугацаанд боловсруулсан байх | 1 | 1 | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар баталсан "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/193 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" УИХ-ын тогтоолын төсөлд санал өгч 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 02/693 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар "Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцүүлж, хуралдааны шийдвэрийн дагуу төсөлд нэмж тусгах зорилт, арга хэмжээний саналыг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/830 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр УИХ-д өргөн барьж, УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн баталсан. Мөн<br>Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан:<br>- Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл;<br>- "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн "Ил уурхайн олборлолтын технологи нэвтрүүлэх төсөл", "Далд уурхайн төсөл", "Ус хангамжийн системийн төсөл", "Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл"; | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Эрдэнэт гангийн үйлдвэр байгуулах төсөл;<br>- Дархан гангийн үйлдвэр байгуулах төсөл;<br>- Алтанширээт аж үйлдвэрийн парк байгуулах төсөл;<br>- Газрын тос дамжуулах хоолой барих төсөл;<br>- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл”, “Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл”, “Уул уурхай-металлург-химийн үйлдвэрлэлийн төсөл”;<br>- Оюутолгойн ордыг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих” зэрэг төсөл болно.<br>Салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад хяналт тавьж, бодлогын дэмжлэг үзүүлсэн. | |
| 3.1.2 | 2 | Салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бодлогын дэмжлэг үзүүлнэ. | - | Хөрөнгө оруулалт үр өгөөжтэй байх | 1 | 1 | Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнд:<br>- Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл;<br>- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Ил уурхайн олборлолтын технологи нэвтрүүлэх төсөл”, “Далд уурхайн төсөл”, “Ус хангамжийн системийн төсөл”, “Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл”;<br>- Эрдэнэт гангийн үйлдвэр байгуулах төсөл;<br>- Дархан гангийн үйлдвэр байгуулах төсөл;<br>- Алтанширээт аж үйлдвэрийн парк байгуулах төсөл;<br>- Газрын тос дамжуулах хоолой барих төсөл;<br>- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл”, “Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл”, “Уул уурхай-металлург-химийн үйлдвэрлэлийн төсөл”;<br>- Оюутолгойн ордыг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих” зэрэг төсөл болно.<br>Салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бодлогын дэмжлэг үзүүлэн ажилласан. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгах төсөл, арга хэмжээний саналыг 2024 оны 01/162 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн ба 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. | 90 |
| 3.1.3 | 3 | Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбогдуулан төслийн | - | Шинээр хэрэгжих төсөл, хөтөлбөр ийн тоо | 2 | 3 | Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын 2020 оны Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээрийн протоколын дагуу Сангийн яамнаас ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ ТД 2020.2036.0” төслийг хэрэгжүүлэх тохиролцоог баталгаажуулж, 2022 оны 4 дүгээр сараас тус яаманд хэрэгжиж эхэлсэн. ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны шийдвэрийн дагуу хоёр тал харилцан тохиролцож, | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэгжүүдтэй хамтран ажиллана. | | | | | төсөл хэрэгжүүлэх гэрээний дуусах хугацаа 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байсныг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаж, санхүүжилтийг 550,000 сая еврогоор нэмэгдүүлж 2,550,000 евро болгосон. Төсөл хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилттэй холбогдуулан төслийн үйл ажиллагааны төлөвлөөг 2023 онд шинэчлэн баталсан ба 2024 оны үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. Төслийн хүрээнд салбарын ажилтнууд /мэргэжилтнүүд-ын чадавхийг бэхжүүлэх, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтууд амжилттай явагдаж байна.<br>Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 2019 оны 6 дугаар сараас эхлэн "Олборлох салбарын засаглалыг сайжруулах" (TA 9752 MON) төсөл хэрэгжиж байна. Төслийн хугацаа 2021 онд дуусахтай холбоотойгоор Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах олон талт итгэлцлийн сангаас 500.0 мян.ам.долларыг 2022-2023 онд олгохоор болж 2022 онд TF0B8169 тоот тусламжийн гэрээнд талууд гарын үсэг зурсан. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх" төслийн үйл ажиллагаа дууссантай холбогдуулан харилцах дансыг хаах тухай албан бичгийг СЯ-нд хүргүүлсэн.<br>Салбарын хэмжээнд дараах 3 төслийг хамтран хэрэгжүүлж байна. Үүнд:<br>► Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ ТД 2020.2036.0" төсөл,<br>► "Олборлох салбарын засаглалыг сайжруулах" (TA 9752 MON) төсөл,<br>► "Уур амьсгалын өөрчлөлт ба ухаалаг уул уурхай (TA 10237-MON)" төсөл.<br>Хэрэгжиж байгаа төслүүдийн 2024 оны төлөвлөгөөнд холбогдох асуудлаар санал өгч, бодлогын дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. | |
| 3.1.4 | 4 | Уул уурхайн салбарт хийгдэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллана. | - | ГШХО-д эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн байх | 70% | 73% | Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажилласан. Энэ хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийг шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон бусад хуулиудтай нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хууль хоорондын уялдааг сайжруулах зарчимд нийцүүлсэн. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар эдийн засаг, үйл ажиллагааны уялдааг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохицуулалтууд тусгагдсан. Мөн хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх заалтууд тусгагдсан. Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар шинэчлэн байгуулсан Ажлын хэсгийн хуралд /2024.03.27 оролцож санал өгсөн.<br>Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжүүлгэд ногдуулах албан татварын хувь хэмжээг оновчтой тодорхойлоход чиглэсэн тооцоо, судалгааг хийсэн.<br>Гадаадын шууд хөрөнгө оруулалтад уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар 73 хувийг эзэлж байна. | |
| 3.1.5 | 5 | Эрдэс баялгийн салбарын сар, улирал, хагас, бүтэн жилийн статистик мэдээллийг нэгтгэн боловсруулах, тайлагнах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах ажлыг шуурхай зохион байгуулна. | - | Мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх | 12 | 12 | Эрдэс баялгийн салбарын сар, улирал, хагас жилийн статистик мэдээллийг нэгтгэн боловсруулах, тайлагнах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах ажлыг тухай бүр шуурхай зохион байгуулсан. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, борлуулалт, хөдөлмөр эрхлэлт, эрдэс бүтээгдэхүүний экспорт, импорт, улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн мэдээллийг боловсруулж, удирдлагад танилцуулсан.<br>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, тоон үзүүлэлтийн талаарх мэдээллийг боловсруулж удирдлагад танилцуулсан. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны зорилтод түвшингийн голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ, голлох эрдэс түүхий эдийн экспортын мэдээллийг боловсруулж хүргүүлсэн. УИХ, Засгийн газрын хуралдаан, уулзалт, хэлэлцүүлэгт хийгдэх танилцуулга, мэдээ мэдээллийг тухай бүр бэлтгэсэн. | 100 |
| 3.1.6 | 6 | Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг олон нийтэд мэдээлэх | - | Жишиг үнийг олон нийтэд мэдээлсэн байх | 6 удаа | 6 удаа | Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 200/А/177 дугаар хамтарсан тушаалаар “Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлэх” үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны 465 дугаар тогтоолын дагуу Ажлын хэсгийн бүрэлдэхүүн сар бүрийн 10-ны дотор хуралдаж “Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд” мэдээлж байна. Монгол Улсын Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 200/А/177 тоот хамтарсан тушаалаар “Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлэх” Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 465 дугаар тогтоолын дагуу Ажлын хэсэг сар бүрийн 10-ны дотор хуралдаж "Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлж ажилласан. | |
| 3.1.7 | 7 | Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, улсын төсвийн орлогын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангана. | - | Мэдээлэл бодитой байх | 4 удаа | 4 удаа | - Салбараас улсын төсөвт 2023 онд төвлөрүүлсэн орлого, 2024 оны орлогын төсөөллийг гаргасан.<br>- Экспортын голлох ашигт малтмалын мэдээллийг сүүлийн 10 жилээр гарган удирдлагад танилцуулсан.<br>- Нүүрсний экспорт, Хятадын нүүрсний импортын талаарх статистик мэдээ мэдээллийг бэлтгэсэн.<br>✓ Алт, зэс, төмөр, нүүрс, жоншны томоохон ордуудын болон хэрэгжиж буй болон хэрэгжүүлэхээр ажиллаж буй төслүүдийн талаарх мэдээ мэдээлэл, судалгааг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн боловсруулж, танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулсан.<br>✓ Нүүрс, алт, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, бусад ашигт малтмалын экспорт /биет хэмжээ, үнийн дүн/-ын мэдээллийг боловсруулж танилцуулсан.<br>✓ Монголын хөрөнгийн биржээр арилжаалж байгаа нүүрс, төмөр, зэсийн баяжмалын экспортын мэдээллийг боловсруулж сайдад танилцуулсан. Хятадын www.sxcoal.com сайтын зарлаж буй үнийн мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн үнийн мэдээлэлтэй харьцуулсан судалгаа хийсэн.<br>Хятадын нүүрсний хэрэглээнд Монгол болон бусад орны нүүрсний эзлэх хувь хэмжээний талаарх мэдээллийг бэлтгэн удирдлагад танилцуулсан. | 100 |
| 3.1.8 | 8 | Уул уурхай, газрын тосны 7 хоногийн мэдээллийг боловсруулж, удирдлагыг шуурхай мэдээллээр хангана. | - | Мэдээлэл тогтоосон хугацаанд гарсан байх | 26 удаа | 26 удаа | Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, улсын төсвийн орлогын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг 7 хоног бүр боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангаж байна. Мөн бүтээгдэхүүн борлуулалтын үнэ ханш, Монголын хөрөнгийнн биржээр арилжаалж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тухай бүр нэгтгэн гаргаж байна. Мэдээллийг Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголбанк, Эрдэнэс Тавантолгой ХК, Fenwei Energy (www.sxcoal.com) зэрэг байгууллагаас 7 хоног тутам авч боловсруулалт хийн Infographic байдлаар удирдлагад танилцуулж байна.<br>► Эрдэс бүтээгдэхүүний төлөвлөгөө /тод/, гүйцэтгэл<br>► Худалдан авсан үнэт металл, үнэ /Монголбанк/<br>► Зэсийн баяжмалын экспорт<br>► Нүүрсний олборлолт, экспорт<br>► Төмрийн хүдэр, баяжмалын экспорт<br>► Газрын тосны олборлолт, экспорт<br>► Монгол Улсын шатахууны үлдэгдэл, нөөц | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ▸ Газрын тосны бүтээгдэхүүний импорт<br>▸ Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл<br>▸ Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө /тод/, гүйцэтгэл<br>Лондонгийн металлын бирж (ww.lme.com)-д зарлагдаж байгаа эрдэс бүтээгдэхүүний үнэ, БНХАУ-ын нүүрсний үнэ (www.sxcoal.com), Bloomberg терминалаас уул уурхайн голлох ашигт малтмалын үнэ, Монголбанкны гадаад валют болон алтны үнэ, бусад эх сурвалжаас мэдээллийг авч байна. | |
| 3.1.9 | 9 | Голлох ашигт малтмалын зах зээлийн үнийн мэдээллийг 7 хоног бүр гарган удирдлагыг мэдээллээр хангана. | - | Мэдээлэл тогтоосон хугацаанд гарсан байх | 26 удаа | 26 удаа | Голлох ашигт малтмалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, улсын төсвийн орлогын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг 7 хоног бүр гаргаж, удирдлагыг мэдээллээр хангаж байна. Мөн голлох ашигт малтмалын борлуулалтын үнэ ханш, Монголын хөрөнгийнн биржээр арилжаалж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тухай бүр нэгтгэн гаргасан. Лондонгийн металлын бирж (ww.lme.com)-д зарлагдаж байгаа эрдэс бүтээгдэхүүний үнэ, БНХАУ-ын нүүрсний үнэ (www.sxcoal.com), Bloomberg терминал (G19)-аас уул уурхайн голлох ашигт малтмалуудын үнэ, Монголбанкны гадаад валют болон алтны үнэ, бусад эх сурвалжаас үнийн мэдээллийг гарган долоо хоног бүр яамны удирдлагад танилцуулсан. Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдаж байгаа нүүрс, төмөр, зэс, жоншны экспортын талаарх мэдээллийг боловсруулж удирдлагыг мэдээллээр хангасан.<br>Эрдэс баялгийн салбарын товч мэдээлэл (Investment Guide 2023-2024)-ийг шинэчлэн боловсруулсан.<br>Холбогдох бусад мэдээ, мэдээллийг тухай бүр шуурхай боловсруулж, яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан. | 100 |
| **3.2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| 3.2.1 | 1 | Нээлттэй засгийн түншлэлийн бодлого, төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах ажлыг зохион байгуулна. | - | Талуудын үйл ажиллагаа уялдсан байх | 1 | 1 | Нээлттэй засаглалын түншлэлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд санал өгсөн. 2021-2024 оны үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2013 оны 381 дүгээр тогтоолын дагуу нэгтгэж, 2024 оны 01/194 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| 3.2.2 | 2 | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголд тусгуулах уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төслүүдийг тодорхой болгоно. | - | Тодотгон боловсруулах төслийн тоо | 1 | 1 | “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд санал өгч 2024 оны 03 дугаар сарын 27-ны 02/693 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төслийг хэлэлцэж, хуралдааны шийдвэрийн дагуу төсөлд нэмж тусгах зорилт, арга | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээний саналыг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/830 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Үүнд:<br>- Эрдэнэтийн ил уурхайн хөрсний тээвэрт мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх;<br>- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хүдэр бэлтгэлийн I шугамын шинэчлэл;<br>- Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрийн хаягдлыг өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх;<br>- Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрийн хаягдлыг хураах сан байгуулах;<br>- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр байгуулах;<br>- "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрс тээврийн конвейерийн систем;<br>- Цагаан цавын гүний усны ордыг ашиглах;<br>- Дорноговь аймагт "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслүүд эдгээр болно. | |
| 3.2.3 | 3 | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөл, Ажлын алба, Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, хянан зохицуулна. | - | Талуудын үйл ажиллагаа уялдсан байх | 1 | 1 | Монголын ОҮИТБС-ын 2023 оны буюу 18 дугаар тайлангийн ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтыг 2024.04.04-ний өдөр зарласан. Сонгон шалгаруулалтаар СИКА ХХК, Гроут Файненс аудит ХХК- ийн түншлэл шалгарч, 2024.05.10-ны өдөр гэрээ байгуулсан. Ажлын хэсгийн 63 дугаар хуралдааныг 2024.07.04-ний өдөр зохион байгуулж, 18 дугаар нэгтгэл тайлангийн хамрах хүрээг тохирч, тулган баталгаажуулалтаар салбарын 125 компанийн тайланг хамруулахаар болсон.<br>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцаж байгаа бөгөөд ОҮИТБС-ын Ажлын албанаас төслийг хэлэлцүүлэх ажлыг идэвхжүүлэх, олон нийтэд ойлгуулах хүрээнд 2024 оны 2-р сард хуулийн төслийг төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлж, санал авсан.<br>Мэдээлэл түгээх ажлыг сайжруулах боломжийг судлах, олборлох салбарын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд шинэ системээр тайлан гаргах аргачлал, зааварчилгааны талаарх сургалтыг ОҮИТБС-ын дэд зөвлөлүүдэд 2024.03.26 болон 2024.04.24-нд цахимаар зохион байгуулж, 21 аймаг, сум дүүргийн 33 төлөөллийг оролцуулсан. Компаниудад шинэ системээр тайлан гаргах сургалтыг Дазо ХХК-тай хамтран зохион байгуулж, 202 компанийн төлөөллийг оролцуулсан.<br>ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газартай хамтран Баталгаажуулалтын семинарыг Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн г хүрээнд 2024.06.03, 04-нд зохион байгуулж, үйл ажиллагааны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөгөөг 2023 оны шинэ стандартын шаардлагад нийцүүлж шинэчилсэн.<br>ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газартай хамтран Төв Ази, Кавказын орнуудын туршлага солилцох семинарыг 2024.06.05-07-нд Улаанбаатарт зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд Монгол, Армен, Казакстан, Кыргыз улсуудын төлөөлөл оролцож, гэрээ, эцсийн өмчлөгч, мэдээлэл өгөгдлийн ил тод байдлын талаар туршлага солилцож, цаашид хамтран ажиллахаар тохирсон.<br>Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төслийн хүрээнд Ажлын хэсгийн гишүүд, төрийн байгууллага, төрийн өмчийн компаниудын мэргэжилтнүүдэд мэдээллийн өгөгдлийн цуврал сургалтыг 6-р сард, эрчим хүчний шилжилт, гэрээний ил тод байдал, авилгаас сэргийлэх сургалтуудыг 8-р сард зохион байгуулсан.<br>Монголын ОҮИТБС-ын 2022 оны Нэгтгэл тайлангийн тухай товч видео контентыг Ажлын албаны www.eitimongolia.mn болон Фейсбүүк хаягаар түгээсэн. Мөн УУХҮЯ, АМГТГ, МУУҮА-ын цахим хуудас, Эрдэс баялгийн тойм, mongolian miningjournal.com, mining.mn, mininginsight.mn сайтуудын веб хуудсанд ААН-үүдийг тайлан гаргах талаар уриалга болон сургалтын зарыг тус тус байршуулж ажилласан.<br>Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн 22-р хуралдааныг 2024.11.29-ний өдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хурлын танхимд зохион байгуулсан. Хуралдаанаар Монголын ОҮИТБС-ын 2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайланг танилцуулж, 2024 оны төлөвлөгөөний биелэлт, 2025 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн баталсан. | |
| 3.2.4 | 4 | Салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагаатай холбоотой үйлдвэрлэлийн болон эдийн засгийн тайлан мэдээг нэгтэн боловсруулж, удирдлагад танилцуулна. | - | Тайланг нэгтгэж, танилцуулсан байх | 1 | 1 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж /Эрдэнэс Монгол групп, Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэс Оюутолгой, Шивээ-Овоо, Багануур, Дарханы төмөрлөгийн үйлдвэр зэрэг/, улсын үйлдвэрийн газрууд /"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ зэрэг/-ын 2024 оны үйл ажиллагааны үр дүнтай холбоотой санхүү, эдийн засгийн болон үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулж удирдлагад танилцуулсан. 2024 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн үзүүлэлтийг нэгтгэж, удирдлагад танилцуулсан. Салбарын төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын үйлдвэрийн газруудын 2024 оны хагас, бүтэн жилийн үйл ажиллагаатай холбоотой санхүү, эдийн засгийн болон үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулсан. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.5 | 5 | Нөөц нь тогтоогдсон, хөрөнгө оруулалт шаардлагатай ашигт малтмалын томоохон ордуудыг ашигт малтмал төрөл бүрээр ангилан танилцуулга бэлтгэнэ. | - | Танилцуулга, мэдээлэл бэлтгэсэн байх | 3 | 3 | Нөөц нь тогтоогдсон боловч хөрөнгө оруулалт шаардлагатай ашигт малтмалын томоохон ордуудыг ашигт малтмал төрөл бүрээр ангилан танилцуулга бэлтгэсэн. Тухайлбал, алт, жонш, төмрийн хүдрийн ордуудыг ашиглахад хөрөнгө оруулалт шаардлагатай төслийн судалгааг хийж, удирдлагад танилцуулсан. Мөн уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын орчны судалгааг Ашигт малтмал, газрын тосны газраар хийлгэж, танилцуулгад ашигласан. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт шаардлагатай төслийн талаарх мэдээллийг АМГТГ-аас авч нэгтгэн боловсруулалт хийж удирдлагад танилцуулсан. 2020-2024 онд ашиглалтад орсон уул уурхай, хүнд үйлдвэрийн төслүүдийн судалгааг холбогдох газар, хэлтсүүдээс нэгтгэн авч боловсруулалт хийж удирдлагад танилцуулсан. | 100 |
| 3.2.6 | 6 | Экспортын голлох ашигт малтмалын зах зээлийн болон хэтийн төлөвийн судалгаа хийж, яамны удирдлагыг шуурхай мэдээллээр хангана. | - | Судалгаа хийж, мэдээллээр хангасан байх | 2 | 2 | - Уул уурхайн салбараас улсын төсөвт 2023 онд төвлөрүүлсэн орлого, 2024 оны орлогын төсөөллийг гаргасан.<br>- Монгол Улсаас экспортолж буй голлох ашигт малтмалын мэдээллийг сүүлийн 10 жилээр боловсруулж удирдлагад танилцуулсан.<br>✓ Алт, зэс, төмөр, нүүрс, жоншны томоохон ордуудын болон хэрэгжиж буй болон хэрэгжүүлэхээр ажиллаж буй төслүүдийн талаарх мэдээ мэдээлэл, судалгааг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн боловсруулж, танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулсан.<br>✓ 2019-2023 оны байдлаар нүүрс, алт, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, баяжмал, бусад ашигт малтмалын экспорт /биет хэмжээ, үнийн дүн/-ын мэдээллийг боловсруулж танилцуулсан.<br>✓ Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдаж байгаа нүүрсний экспортын талаарх мэдээлэл, Хятадын www.sxcoal.com сайтын зарлаж буй үнийн мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн үнийн мэдээлэлтэй харьцуулсан судалгаа хийсэн.<br>www.sxcoal.com сайтаас Хятадын нүүрсний хэрэглээнд Монгол болон бусад орны нүүрсний эзлэх хувь хэмжээний талаарх мэдээллийг бэлтгэн удирдлагад танилцуулсан. Голлох ашигт малтмалын экспортын мэдээллийг Гаалийн ерөнхий газраас авч нэгтгэн боловсруулалт хийж, 7 хоног бүр удирдлагад танилцуулсан. | 100 |
| 3.2.7 | 7 | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, өсөн нэмэгдэх роялтийг ногдуулах хувь хэмжээний талаар судалгаа, танилцуулга бэлтгэнэ. | - | Судалгаа хийж, мэдээллээр хангасан байх | 2 | 2 | Хуулийн төслийг шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон бусад хуулиудтай нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хууль хоорондын уялдааг сайжруулах зарчимд нийцүүлсэн. Эдийн засаг, үйл ажиллагааны уялдааг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалтууд тусгагдсан. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, олон улсын уул уурхайн салбарт мөрдөж байгаа хуулиудыг өөрийн орны эрх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зүйн орчин, бүс нутгийн онцлогтой харьцуулсан судалгаа, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжүүлгэд ногдуулах албан татварын хувь хэмжээг оновчтой тодорхойлоход чиглэсэн тооцоо, судалгааг хийж, удирдлагад танилцуулсан. Голлох ашигт малтмалын 2020-2023 оны улсын төсөвт төвлөрүүлсэн АМНАТ болон өсөн нэмэгдэх АМНАТ, эрдэс бүтээгдэхүүний экспорт, ашигт малтмалын ханшийн талаарх мэдээллийг боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн | |
| 3.2.8 | 8 | Арга хэмжээ 2.1. ЗГХЭГ-ын дэргэдэх e-mongolia академийн хөгжүүлэлт хийж буй www.sudalgaa.gov.mn судалгааны нэгдсэн системд салбарын хэмжээнд гүйцэтгүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг байршуулсан байна. | - | Эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг цахим системд байршуулсан байх | 5 | 5 | E-mongolia академийн хөгжүүлэлт хийж буй www.sudalgaa.gov.mn судалгааны нэгдсэн системд салбарын хэмжээнд гүйцэтгүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг байршуулж байна. Тухайлбал, геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн чиглэлээр улсын төсөв болонн шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, төслүүдийн талаарх мэдээллийг тухай бүр байршуулж байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд 18 удаагийн нэгтгэл тайланг дээрх нэгдсэн системд байршуулаад байна. Sudalgaa.gov.mn цахим хуудсанд УУХҮЯ-ны захиалгаар улсын төсвөөр болон гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 2020-2023 онд хийгдсэн эрдэм шинжилгээ судалгааны ажлуудыг нэгтгэн байршуулсан. | 100 |
| 3.2.9 | 9 | Удирдах дээд байгууллага, УУХҮ-ийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал болон холбогдох байгууллагын хамтарсан тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн 9бүрэлдэхүүнд ажиллаж, хэрэгжилт, үр дүнг тайлагнана. | - | Гаргасан санал, зөвлөмж, дүгнэлт оновчтой байх | 6 удаа | 8 удаа | - ШУТИС-ийн захирлын 2023 оны А/373 дугаар тушаалаар Геологи, уул уурхайн сургуулийн "Уул уурхайн ашиглалтын технологи хөтөлбөр"-ийн бакалаврын дипломын ажил, төсөл хамгаалуулах төгсөлтийн шалгалтын комиссы ахалж ажилласан.<br>- УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/138 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд "Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, яамны удирдлагын зөвлөлд танилцуулж батлуулсан.<br>- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/192 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд Монгол Улс, БНСУ-ын хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн эхний шатны үр дүнгийн хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон.<br>- "Монголын эдийн засгийн форум 2024" чуулга уулзалтыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүний төслийг боловсруулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.04.30-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар батлуулсан.<br>- Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/12 дугаар тушаалаар байгуулсан "Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн Үнэлгээний хороо"-ны бүрэлдэхүүнд ажиллаж, "Аж үйлдвэрийн чиглэлээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас гарсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд судалгаа, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах" болон "Аж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлдвэржилтийн бүтээн байгуулалттай холбоотой суурьшлын бүс байгуулах, байршил, кластерын зураглалын судалгаа" зөвлөх үйлчилгээний 2 багц тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.<br>- Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах боломжтой ордын талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг"-ийн тушаал, удирдамжийн төслийг боловсруулсан.<br>- Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/138 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд холбогдох санал боловсруулсан.<br>- Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/63 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгах зорилт, арга хэмжээний санал боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж, санал боловсруулсан.<br>- "Зэсийн баяжмалыг биржээр арилжаалах нь" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан.<br>- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/107 дугаар тушаалаар Монгол Улс, БНСУ-ын хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулахад Солонгосын талтай хэлэлцээ хийх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, холбогдох асуудлаар санал солилцсон. | |
| 3.2.10 | 10 | Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн тайлагнах ажлыг зохион байгуулна. | - | Тухай бүр тайлагнасан байх | 4 удаа | 4 удаа | Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнг улирал бүр Эдийн засаг, хөгжлийн яаманд тайлагнасан. Үүнд: Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн "Ил уурхайн олборлолтын технологи нэвтрүүлэх төсөл", "Далд уурхайн төсөл", "Ус хангамжийн системийн төсөл", "Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл", Эрдэнэт гангийн үйлдвэр байгуулах төсөл, Дархан гангийн үйлдвэр байгуулах төсөл, Алтанширээт аж үйлдвэрийн парк байгуулах төсөл, Газрын тос дамжуулах хоолой барих төсөл, "Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл", "Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл", "Уул уурхай-металлург-химийн үйлдвэрлэлийн төсөл", Оюутолгойн ордыг түшиглэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зэрэг төсөл болно.<br>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, онцлох ажлууд" сэдэвт хэлэлцүүлэгтэй холбогдуулан мэдээлэл бэлтгэж удирдлагад танилцуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан "Шинэ сэргэлтийн бодлого-2024" зөвлөлдөх уулзалтад оролцож, санал солилцсон. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэн улирал бүр тайлагнах ажлыг зохион байгуулсан. | |
| 3.2.11 | 11 | Монгол Улсын уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахад бодлогын дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана. | - | Судалгааны ажилд дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангасан байх | 1 удаа | 1 удаа | -"Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын нийгэм эдийн засгийн үнэлгээ"-ний ажлын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санал дүгнэлт өгөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мөн тухайн ажлын техникийн даалгаварыг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/34 дүгээр тушаалаар байгуулсан.<br>- Ажлын хэсгийн хурлыг 2023 онд 3 удаа, 2024 онд 2 удаа зохион байгуулж, үнэлгээнд шаардлагатай мэдээллийн өгөдөл цуглуулах болон Ажлын хэсгийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.<br>- Мөн Ажлын хэсгийн хуралдаанаар НЭЗҮ хийх ажлын даалгаварт тусгах судалгаа, мэдээ мэдээллийг нэгтгэж, удирдлагад танилцуулсан.<br>- Салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний ажлын даалгавар боловсруулах хувь хүн хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын даалгаврын төслийг боловсруулан ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-т хүргүүлсэн. Канад улсын уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн үнэлгээ, зөрчилдөөнийг шийдвэрлэх, олон нийт иргэдийн оролцоо, уул уурхайн салбарын цахим үйлчилгээ, байгаль орчны салбарын асуудал ба уурхайн хаалтын талаар Канад улсын Бритиш Колумби мужийн Ванкувер, Виктория хотноо албан томилолтоор ажиллаж туршлага судалсан. Төслийн хүрээнд салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний ажлын даалгавар боловсруулах хувь хүн хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлыг ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад нэг санал ирсэн боловч холбогдох шаардлагыг хангаагүйн улмаас 2024 оны 8 дугаар сард тендер амжилтгүй болсон.<br>Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан "Мэргэшсэн төслийн удирдагч (Project Management Professional)" бэлтгэх хүсэлтийг BGR-д хүргүүлсэн боловч сонгон шалгаруулалт амжилтгүй болсон. Монгол Улсын уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг боловсруулах хөтөлбөрт өөрчлөлт оруулж, холбогдох сургалтад 5 албан хаагч хамрагдаад байна. | 90 |
| 3.2.12 | 12 | Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төлөвлөх, зохион байгуулах, тайлагнана. | - | Чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байх | 2 | 2 | Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах ажлыг тухай бүр гүйцэтгэж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлсэн. Тухайлбал, СХОГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан боловсруулах, батлуулах, газрын сар, улирлын үйл ажиллагааны үр дүнг төлөвлөх, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэгтгэх, тайлагнах, чиг үүргийн хэрэгжилтийг хангах ажлыг тухай бүр зохион байгуулж ажилласан. | |
| 3.2.13 | 13 | Ажлыг сар, улирлаар төлөвлөн батлуулж тайлагнана. | - | Сар улирлаар төлөвлөн тайлагна сан байх | 2 | 2 | Газар, хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг 7 хоног, сар, улирал, хагас, бүтэн жилээр төлөвлөн батлуулах, хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан. Мөн удирдлагаас өгсөн үүргийн дагуу шуурхай мэдээ, мэдээлэл гаргах, дотоод, гадаад арга хэмжээ /хурал, зөвлөлгөөн/-ний танилцуулга, мэдээлэл бэлтгэх зэрэг ажлыг тухай бүр шуурхай хэрэгжүүлж ажилласан. | 100 |

## ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | "Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт боловсруулах арга зүй" сэдэвт уулзалт, хэлэлцүүлэгт оролцох | Төрийн нарийн бичгийн дарга | Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохион байгуулсан "Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт боловсруулах арга зүй" хэлэлцүүлэгт оролцож санал солилцсон.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.01.02/2024.01.06 |
| 2 | Канад Улсын Торонто хотод зохион байгуулах "Уул уурхайн хайгуул, олборлогчдын чуулга уулзалт (PDAC)"-д бэлтгэл ажлыг хангах | УУХҮ-ийн сайд | Канад Улсын Торонто хотод 2024 оны 3 дугаар сард зохион байгуулсан "Уул уурхайн хайгуул, олборлогчдын чуулга уулзалт (PDAC)"-ын бэлтгэл ажлын зардлыг СЯ-аар батлуулж, арга хэмжээний үеэр хийх мэдээллийг бэлтгэсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2023.03.02/2023.03.18 |
| 3 | УУХҮ-ийн сайдын аймгуудын Засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээний төсөлд санал өгөх | УУХҮ-ийн сайд | УУХҮ-ийн сайдын аймгуудын Засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээний төсөлд санал өгч, гэрээ байгуулах үеэр хийх мэдээллийг бэлтгэсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.01.22/2024.01.26 |
| 4 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулах | Төрийн нарийн бичгийн дарга | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу боловсруулж 2024.01.24-ний өдрийн 01/193 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>Эхлэх /дуусах огноо: 2024.01.16/2024.01.24 |
| 5 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан төслүүдийн хэлэлцүүлэгт оролцох | УУХҮ-ийн дэд сайд | "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д тусгагдсан төслүүдийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцох, хэрэгжүүлэх үе шат, хэмжих шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг боловсруулах хэлэлцүүлэгт оролцож, санал өгсөн. Мөн "Бүсчилсэн хөгжлийн салбар хуралдаан болон нэгдсэн хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон.<br>Эхлэх /дуусах огноо: 2024.02.13/2024.02.13 |
| 6 | Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар холбогдох судалгаа хийж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалын төсөлд санал өгөх | Төрийн нарийн бичгийн дарга | Ашигт малтмалын тухай хуульд 2008-2023 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн судалгааг гаргаж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгсөн.<br>Эхлэх /дуусах огноо: 2024.02.06/2024.03.01 |
| 7 | Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх | УУХҮ-ийн дэд сайд | "Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийн хүрээнд хуулийн төсөлд санал өгсөн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.04.14/2024.05.01 |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | “Алсын харaa-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, онцлох ажлууд” сэдэвт хэлэлцүүлэгтэй холбогдуулан мэдээлэл бэлтгэх | УУХҮ-ийн дэд сайд | “Алсын харaa-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, онцлох ажлууд” сэдэвт Ерөнхий сайдын илтгэлтэй холбогдуулан танилцуулга, мэдээлэл бэлтгэж удирдлагад танилцуулсан.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.01.15/2024.02.09 |
| 9 | “Монголын эдийн засгийн форум-2024” Олон улсын чуулганы салбар хуралдаанаар хэлэлцэх асуудлаар мэдээлэл бэлтгэх | УУХҮ-ийн сайд | “Монголын эдийн засгийн форум-2023” чуулга уулзалтын салбар хуралдаанаар хэлэлцэх асуудлаар танилцуулга, мэдээлэл бэлтгэсэн. Ажлын хэсгийн тушаалын төсөл боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.03.11/2024.03.30 |
| 10 | Экспортод гарч буй голлох ашигт малтмалын зах зээлийн үнийн мэдээллийг боловсруулах | Байгууллагын удирдлага | Экспортод гарч буй голлох ашигт малтмалын зах зээлийн үнийн мэдээллийг холбогдох эх сурвалжуудаас авч боловсруулалт хийн удирдлагад танилцуулсан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-06.01 |
| 11 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт УУХҮЯ-ны зүгээс тусгуулах төсөл хөтөлбөрийн саналыг ЭЗХЯ-нд хүргүүлэх | ЭЗХЯ | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж байгаатай холбогдуулан УУХҮ-ийн яамны зүгээс тусгуулах төсөл хөтөлбөрийн саналыг бодлогын газруудаас нэгтгэн авч ЭЗХЯ-нд цахимаар хүргүүлсэн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.02.02/2024-02.28 |
| 12 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023 оны үйл ажиллагааны үр дүн, онцлох ажлуудын талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулах | ЗГХЭГ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023 оны үйл ажиллагааны үр дүн, онцлох ажлуудын талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т /2024.01.05/ хүргүүлсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.01.02/2024.01.05 |
| 13 | Байгууллага /УУХҮЯ/-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл боловсруулах | Төрийн нарийн бичгийн дарга | Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, удирдлагын зөвлөлд танилцуулж батлуулсан.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.01.02/2024.01.16 |
| 14 | “Монгол Улсын Засгийн газрын 2021-2023 онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд” товхимолд салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн онцлох арга хэмжээний талаар тусгах мэдээллийг нэгтгэх | УУХҮ-ийн сайд | Засгийн газрын 2021-2023 онд хэрэгжүүлсэн онцлох ажлуудын товхимолд салбарын талаар тусгах мэдээлэлд яамны газар, хэлтсүүд болон АМГТГ, ҮГА-наас холбогдох мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-ын Хэвлэлийн албанд хүргүүлсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.01.15/2024.01.20 |
| 15 | “Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний төсөлд санал өгөх | Төрийн нарийн бичгийн дарга | Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлтэй танилцаж, ТЗУГ-т санал хүргүүлсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.01.15/2024.01.19 |
| 16 | Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан хийлгэх судалгаа, мэдээллийн саналыг боловсруулах | Төрийн нарийн бичгийн дарга | Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан хийлгэх судалгаа, мэдээллийн саналыг ТЗУГ-т /2024.01.12/ хүргүүлсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.01.05/2024.01.12 |
| 17 | Усны орчны чанарын үзүүлэлт, Усны чанарт дээж авах заавар, Гүний уснаас дээж авах стандартуудын төсөлтэй танилцаж санал өгөх | ХҮБГ | Усны орчны чанарын үзүүлэлт, Усны чанарт дээж авах заавар, Гүний уснаас дээж авах стандартын төсөлтэй танилцан санал өгсөн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.02.15/2024.02.20 |
| 18 | Бүсчилсэн хөгжлийн урьдчилсан хэлэлцүүлгийн хүрээнд Говийн бүсийн хөгжлийн асуудлаар мэдээлэл бэлтгэж оролцох | УУХҮ-ийн сайд | ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжлийн урьдчилсан хэлэлцүүлэг”-ийн хүрээнд Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн хөгжлийн асуудлаар мэдээлэл бэлтгэж санал солилцож оролцсон.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.03.15/2024.03.19 |
| 19 | “Бүсчилсэн хөгжлийн зөвлөлгөөний нэгдсэн хуралдаан”-д мэдээлэл бэлтгэн оролцох | УУХҮ-ийн сайд | Бүсчилсэн хөгжлийн зөвлөлгөөний нэгдсэн хуралдаанд оролцож, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөлд санал өгсөн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.02.05/2024.02.09 |

| | | | |
|---|---|---|---|
| 20 | Хойд бүсийн аймгуудын хөгжлийн асуудлаар мэдээлэл бэлтгэн оролцох | УУХҮ-ийн сайд | Орхон, Булган, Хөвсгөл аймгийн хөгжлийн талаарх хэлэлцүүлэгт мэдээлэл бэлтгэн оролцож, санал солилцсон.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.02.15/2024.02.17 |
| 21 | “Монгол Улсын уул уурхайн салбар ба гадаадын шууд хөрөнгө оруулалт” сэдэвт хэлэлцүүлэгт мэдээлэл бэлтгэн оролцох | Төрийн нарийн бичгийн дарга | Гадаад харилцааны яамтай хамтран “Монгол Улсын уул уурхайн салбар ба гадаадын шууд хөрөнгө оруулалт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.02.25/2024.02.28 |
| 22 | Канадын хайгуулч, олборлогчдын холбооноос зохион байгуулах PDAC /Prospectors & Developers Association of Canada/-2024 олон улсын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтад оролцох ААН, компанийн төлөөлөлтэй уулзах, санал солилцох | УУХҮ-ийн сайд | Канадын хайгуулч, олборлогчдын холбооноос (PDAC-) зохион байгуулах “PDAC-2024” чуулга уулзалтын талаар Батбродерс Майнинг болон Монголиан Коппер компанийн удирдлагатай /төлөөлөлтэй/ уулзаж, зохион байгуулалтын асуудлаар санал солилцсон.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.02.15/2024.02.16 |
| 23 | Монгол Улс - БНСУ-ын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах “Ашигт малтмал-Төмөр замыг холбосон Төр, хувийн хэвшлийн түншлэл” сэдэвт олон улсын семинарт мэдээлэл бэлтгэж оролцох | Төрийн нарийн бичгийн дарга | Зам, тээврийн хөгжлийн яам, БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамны хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан “Ашигт малтмал-Төмөр замыг холбосон Төр, хувийн хэвшлийн түншлэл” сэдэвт олон улсын семинарт оролцож, санал солилцсон.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.03.15/2024.03.17 |
| 24 | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох | Төрийн нарийн бичгийн дарга | Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож, санал өгсөн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.03.25/2024.03.26 |
| 25 | Усны үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгөх | Төрийн нарийн бичгийн дарга | Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловсруулсан “Усны үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөлд санал өгч ХҮБГ-т хүргүүлсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.04.15/2024.04.17 |
| 26 | Монгол Улсын Ерөнхий сайдын УИХ-ын 2024 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд хийх мэдээлэлд тусгах санал боловсруулах | ЗГХЭГ | Монгол Улсын Ерөнхий сайдын УИХ-ын 2024 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд хийх мэдээлэлд тусгах саналыг нэгтгэн боловсруулж хүргүүлсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.03.15/2024.03.19 |
| 27 | “Зэсийн баяжмалыг биржээр арилжаалах нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулах | УУХҮ-ийн сайд | “Зэсийн баяжмалыг биржээр арилжаалах нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулахад оролцсон.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.03.25/2024.03.27 |
| 28 | “Бүсчилсэн хөгжил, орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд” сэдэвт хурал мэдээлэл бэлтгэн оролцох | Төрийн нарийн бичгийн дарга | Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил, орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд” хурал оролцож, санал солилцсон.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.04.15/2024.04.19 |
| 29 | “Боомтын сэргэлт-2024” Үндэсний чуулган, хэлэлцүүлгийн арга хэмжээнд мэдээлэл бэлтгэн оролцох | УУХҮ-ийн сайд | Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос зохион байгуулсан “Боомтын сэргэлт-2024” Үндэсний чуулган, хэлэлцүүлгийн арга хэмжээнд оролцож, санал солилцсон.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.02.25/2024.02.28 |
| 30 | Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд болон стратегийн ордод хамааруулах боломжтой ордуудын талаар мэдээлэл бэлтгэх | Төрийн нарийн бичгийн дарга | Стратегийн болон стратегийн ордод хамааруулах боломжтой ордуудын талаар мэдээлэл бэлтгэж удирдлагад танилцуулсан.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.04.18/2024.04.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 31 | ”Монголын эдийн засгийн форум 2024”-ын үеэр Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар хуралдааныг зохион байгуулах “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг боловсруулах | Төрийн нарийн бичгийн дарга | “Монголын эдийн засгийн форум 2024” олон улсын чуулга уулзалтыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн-ийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.04.30-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар батлуулсан.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.04.15/2024.04.30 |
| 32 | БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулах “Азийн уул уурхайн салбарын инноваци хөгжил” сэдэвт чуулга уулзалтад УУХҮ-ийн дэд сайдын хийх мэдээллийг бэлтгэх | УУХҮ-ийн дэд сайд | БНХАУ-ын Бээжин хотод 2024.05.21-22-ны өдрүүдэд зохион байгуулсан “Азийн уул уурхайн салбарын инноваци хөгжил” сэдэвт чуулга уулзалтад УУХҮ-ийн дэд сайдын хийсэн мэдээллийг бэлтгэж хүргүүлсэн.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.05.15/2024.02.22 |
| 33 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын Засгийн газартай хамтран ажиллах Санамж бичгийн төслийг боловсруулж танилцуулах | УУХҮ-ийн дэд сайд | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын Засгийн газартай хийх Санамж бичгийн төслийг боловсруулж, 2024.04.30-ны өдрийн 03/953, 3/954 дүгээр албан бичгээр салбарын мэргэжлийн холбоод, ТББ-д хүргүүлж, удирдлагад танилцуулсан.<br>Эхлэх/дуусах огноо: 2024.04.30/2024.05.30 |
| 34 | Улсын хөрөнгө оруулалтын чадавх бэхжүүлэх төслийн хэлэлцүүлэгт оролцох | Төрийн нарийн бичгийн дарга | Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамтай хамтран зохион байгуулсан тус хэлэлцүүлэгт оролцож, холбогдох асуудлаар санал солилцсон. |
| 35 | “Эдийн засгийн форум-2024” олон улсын чуулга уулзалтад оролцох | УУХҮ-ийн сайд | “Эдийн засгийн форум-2024” олон улсын чуулга уулзалтын хүрээнд зохион байгуулсан “Уул уурхайн салбар хуралдаан”-д оролцож, санал солилцсон. |
| 36 | “Салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашдын зорилт” сэдвээр мэдээлэл бэлтгэх | Төрийн нарийн бичгийн дарга | “Салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашдын зорилт” мэдээлэл бэлтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. |
| 37 | “Mongolian Mining Week-2024” олон улсын чуулга уулзалтын хүрээнд холбогдох мэдээлэл бэлтгэж, зохион байгуулалтад оролцох | АҮЭБ-ийн сайд | “Mongolian Mining Week-2024” болон “MinePro-2024” олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэнг 2024.10.02-05-ны өдрүүдэд Тайж хайрхан уулын бэлд амжилттай зохион байгуулсан. |
| 38 | Австрали Улсад зохион байгуулагдах “Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн нөөц (IMARK)-2024” чуулга уулзалтад АҮЭБ-ийн сайдын хийх мэдээлэл, танилцуулгыг бэлтгэх | АҮЭБ-ийн сайд | “Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн нөөц (IMARK)-2024” чуулга уулзалтад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хийх мэдээллийг бэлтгэж удирдлагад танилцуулсан. |
| 39 | Монгол Улс, БНСУ хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд шаардагдах аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж болон холбогдох мэдээллийг боловсруулах | АҮЭБ-ийн сайд | Монгол Улс, БНСУ хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд шаардагдах аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж болон холбогдох мэдээллийг ГХЯ, ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. |
| 40 | Эрдэс баялгийн салбарт баримталж буй бодлогын баримт бичгүүдийн жагсаалт, танилцуулгыг боловсруулж танилцуулах | Төрийн нарийн бичгийн дарга | Эрдэс баялгийн салбарт баримталж буй бодлогын баримт бичгүүдийн жагсаалт түүний танилцуулгыг боловсруулж яамны удирдлагад танилцуулсан. |
| 41 | Хамтарсан Засгийн газарт орсон намуудын мөрийн хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний жагсаалтыг боловсруулж танилцуулах | АҮЭБ-ийн сайд | Хамтарсан Засгийн газарт орсон улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний жагсаалтыг боловсруулж, яамны удирдлагад танилцуулсан. |

| | | | |
|---|---|---|---|
| 42 | Илтгэл танилцуулга боловсруулж танилцуулах | АҮЭБ-ийн сайд | Mining Week 2024 арга хэмжээнд АҮЭБ-ийн сайдын “Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлого” илтгэл, хэлэх үгийг боловсруулж танилцуулсан. |
| 43 | Илтгэл танилцуулга боловсруулж танилцуулах | АҮЭБ-ийн сайд | Боловсруулах үйлдвэрүүдийн судалгаа, байршлын талаарх танилцуулгыг боловсруулж АҮЭБ-ийн сайдын зөвлөхөд танилцуулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. |
| 44 | Илтгэл танилцуулга боловсруулж танилцуулах | Төрийн нарийн бичгийн дарга | China Mining 2024 арга хэмжээнд АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатарын “Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлого” илтгэлийг боловсруулж танилцуулсан. |
| 45 | Илтгэл танилцуулга боловсруулж танилцуулах | АҮЭБ-ийн сайд | Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын талаар хийж буй хэлэлцээрийн тухай танилцуулгыг боловсруулж танилцуулсан. |
| 46 | Илтгэл танилцуулга боловсруулж танилцуулах | Төрийн нарийн бичгийн дарга | Эрдэс бүтээгдэхүүний борлуулалтын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай илтгэлийг боловсруулж танилцуулсан. |
| 47 | Илтгэл танилцуулга боловсруулж танилцуулах | АҮЭБ-ийн сайд<br>Төрийн нарийн бичгийн дарга | “Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Сангийн яам, Монгол Улсын яам хоорондын “Инновацийн технологи, эрчим хүч, ашигт малтмал, шилдэг туршлага, эдийн засгийн ерөнхий хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичиг” сэдэвт шинжээчдийн цахим уулзалтын илтгэлийг боловсруулж, хуралд оролцсон. |
| 48 | Илтгэл танилцуулга боловсруулж танилцуулах | АҮЭБ-ийн сайд<br>Төрийн нарийн бичгийн дарга | Монгол-Францын ураны төсөл, Цөмийн энергийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын хэлэлцээрийн явц, Конвенц, конвенцын нэмэлт, өөрчлөлт, протоколыг соёрхон батлах тухай хууль, Орано майнинг компанитай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээний ажлын явцын талаар илтгэл боловсруулж, танилцуулсан. |

**ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| № | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх ажил | Эхлэх, дуусах огноо |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” | | | | |
| 2.1 | Арга хэмжээ 1.<br>Хариуцсан ажил, албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, хурал, зөвлөгөөнд оролцоно. | Төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл, оролцоог хангах. | ► “Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт боловсруулах арга зүй” уулзалт, хэлэлцүүлэг<br>► Олон улсын тайлангийн стандартын харьцуулалт болон хөрвүүлэлт, ашигт малтмалын баялаг ба ордын эдийн засгийн тооцоолол” сургалт<br>► “Төслүүдийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, хэрэгжүүлэх үе шат, шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал” хэлэлцүүлэгт оролцсон.<br>► БНХАУ-ын Шанхай хотод болсон Хөгжиж буй орнуудын төр, хувийн хэвшлийн түншлэлийн загвар боловсруулах менежментийн сургалт.<br>► Канад Улсын Торонто хотод болсон уул уурхайн хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад оролцож, туршлага судалсан.<br>► Уул уурхайн мэргэшсэн инженер-эдийн засагчийн зэрэг олгох сургалтад хамрагдсан.<br>► Европын холбооны IDTM төслийн хүрээнд “Гарал үүслийн дүрэм”-ийн сургалтад хамрагдсан.<br>► Улсын хөрөнгө оруулалтын чадавхи бэхжүүлэх сургалтад хамрагдсан. | 2024.01.01<br>2024.12.31 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | *Биелэлтийн хувь: 100* | |
| 2.2 | Арга хэмжээ 2.<br>Төрийн албаны сургалтын хөтөлбөрт хамрагдана. | Мэдлэг олгох болон мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх. | ► Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "7:4:10" сургалтад 7хоног бүр хамрагдсан.<br>► "Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх" хөтөлбөрт хамрагдсан.<br>► "Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ" төслийн хүрээнд Power Point (Creative Presentation Studio төв)-ын ахисан түвшний сургалт<br>► Microsoft PowerPoint (Creative Presentation Studio сургалтын төв)-ын ахисан түвшний сургалт, Adobe Photoshop-ын дунд шатны сургалтад хамрагдсан.<br>*Биелэлтийн хувь: 100* | 2024.01.01<br>2024.12.31 |
| 2.3 | Арга хэмжээ 3.<br>Гадаад хэлний мэдлэг, мэдээллийн технологийн болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдана. | Гадаад хэлний мэдлэг, мэргэшлийн ур чадвар сайжирч, ахисан түвшинд хүрсэн байх. | ► "Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ" төслийн хүрээнд англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтад хамрагдсан.<br>► Цахим гарын үсгийн тухай ойлголт, системийн шийдэл, хэрэглээний сургалтад хамрагдсан.<br>► Coral Draw, Adobe Illustrator, Adobe Photoshop, ArcGIS, Microsoft Excel (Function), Microsoft PowerPoint (Morph) программуудыг эзэмшсэн.<br>*Биелэлтийн хувь: 90* | 2024.01.01<br>2024.12.31 |

**ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:**
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
*(албан тушаал)*

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ**
................................ /С.ЖАВХЛАНБААТАР/
*(гарын үсэг)*
2024.12.20
*(огноо)*

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
*(албан тушаал)*

**НЭГЖИЙН ДАРГА**
................................ /Б.ӨНӨМӨНХ/
*(гарын үсэг)*
2024.12.09
*(огноо)*

**ТАЙЛАГНАСАН:**
Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга /хуучин нэрээр/
*(албан тушаал)*

**НЭГЖИЙН ДАРГА**
................................ /Э.БАТБОЛД/
*(гарын үсэг)*
2024.12.09
*(огноо)*